



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Баянхутаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2024/198/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.open.audit.mn

Хэнтий аймаг

Чингис хот

2024 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар

Утас: 70562112

Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа

Утас: 99775390

Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

Их наяд аудит ХХК-ийн

Захирал: Х.Ариунзул

Утас: 99077062

Цахим хаяг: ikhayadaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23118 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг бог
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2024-03-11 № 250

талай _____ -ны № _____ -т

Г _____ Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Баянхутаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Баянхутаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд сургуулийн интернэт орчныг сайжруулах 8 ширхэг тоног төхөөрөмж зэрэг 23,807.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг орлогод авч, Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын 301 дугаар албан бичгийн дагуу 623.5 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж, татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлалгалын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж

20240343

хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд болон хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, 2023 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн төсвийг 93.2 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	130,944,449.98	126,073,758.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	44,127,474.18	36,278,836.80
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	44,127,474.18	36,278,836.80
31210	Төгрөг	44,127,474.18	36,278,836.80
31211	Төрийн сангийн харилцах	44,127,474.18	36,278,836.80
33	АВЛАГА	77,505.40	224,423.40
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	39,074.00	39,074.00
33500	Бусад авлага	38,431.40	185,349.40
33510	Байгууллагаас авах авлага	38,431.40	185,349.40
34	УРЬДЧИЛГАА	-	2,000,000.00
34710	Урьдчилгаа тооцоо	-	2,000,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	2,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	86,739,470.40	87,570,498.10
35100	Түүхий эд материал	36,600.00	649,000.00
35110	Тусгай зориулалттай материал	-	649,000.00
35130	Эм боох материал	36,600.00	-
35400	Хангамжийн материал	83,952,870.40	84,171,498.10
35410	Бичиг хэргийн материал	1,387,918.00	601,200.00
35420	Аж ахуйн материал	60,639,870.00	62,429,610.00
35430	Сэлбэг хэрэгсэл	930,000.00	930,000.00
35450	Барилгын засварын материал	4,468,500.00	3,070,150.00
35460	Хүнсний материал	423,459.40	1,804,040.10
35470	Бусад хангамжийн материал	16,103,123.00	15,336,498.00
35600	Мал амьтад	2,750,000.00	2,750,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,003,968,565.11	1,016,132,571.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,003,968,565.11	1,016,132,571.24
39200	Биет хөрөнгө	997,086,565.11	1,009,250,571.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	998,753,068.00	998,753,068.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(112,399,971.63)	(144,294,329.31)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	134,609,762.11	167,210,214.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	(83,913,792.60)	(88,944,594.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,505,656.81	76,441,328.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,476,002.42)	(27,177,786.27)
39214	Бусад үндсэн хөрөнгө	35,032,740.00	35,032,740.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,689,833.36)	(8,435,007.28)
39217	Ном	664,938.20	664,938.20
39300	Биет бус хөрөнгө	6,882,000.00	6,882,000.00
39301	Програм хангамж	730,000.00	730,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(730,000.00)	(730,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,882,000.00	6,882,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,134,913,015.09	1,142,206,329.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,001.00	107,724.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,001.00	107,724.80
41300	Өглөг	30,001.00	107,724.80
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	77,286.40
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	437.40
41360	Бусад өглөг	30,001.00	30,001.00
41361	Байгууллагад төлөх өглөг	30,001.00	30,001.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,134,883,014.09	1,142,098,604.74
51	Засгийн газрын хувь оролцоо	1,134,883,014.09	1,142,098,604.74
51100	Засгийн газрын оруулсан капитал	262,543,991.52	262,543,991.52
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	262,543,991.52	262,543,991.52

51200	Хуримтлагдсан үр дүн	(95,621,958.81)	(88,406,368.16)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,230,466,986.50)	(95,621,958.81)
51220	Тайлант үеийн үр дүн	1,134,845,027.69	7,215,590.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	967,960,981.38	967,960,981.38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,134,913,015.09	1,142,206,329.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,780,857,678.26	719,018,494.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,159,412,778.26	59,960,194.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,159,412,778.26	59,960,194.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,132,400.00	2,045,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,132,400.00	325,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,720,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,072,699,415.46	53,998,958.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	84,580,961.80	3,915,736.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	621,444,900.00	659,058,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	453,788,100.00	492,497,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	453,788,100.00	492,497,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	167,656,800.00	166,561,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	167,656,800.00	166,561,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	646,012,650.57	711,802,903.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	646,012,650.57	711,802,903.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	619,267,812.58	695,007,160.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	332,565,652.52	405,160,569.81
210101	Үндсэн цалин	239,458,445.52	285,124,264.04
210102	Нэмэгдэл	67,784,613.00	100,469,546.07
210104	Урамшуулал	8,943,397.00	19,566,759.70
210105	Гэрээт ажлын хөлс	16,379,197.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,958,218.25	50,998,469.37
210201	Тэтгэврийн даатгал	28,574,638.83	34,677,360.43
210202	Тэтгэмжийн даатгал	3,380,004.50	4,624,614.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,668,382.49	3,254,211.95
210204	Ажилгүйдлийн даатгал	664,230.20	766,011.92
210205	Эрүүл мэндийн даатгал	6,670,962.23	7,676,270.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	140,832,884.26	146,260,065.36
210301	Гэрэл, цахилгаан	4,123,147.26	6,885,929.36
210302	Түлш, халаалт	134,402,137.00	134,415,336.00
210303	Цэвэр, бохир ус	2,307,600.00	4,958,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,899,697.00	6,373,555.00
210401	Бичиг хэрэг	1,905,647.00	505,959.00
210402	Тээвэр, шатахуун	971,000.00	-
210404	Ном, хэвлэл	-	1,663,946.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,023,050.00	4,203,650.00
2105	Нормативт зардал	7,697,918.20	9,399,535.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200,400.00	36,600.00
210502	Хоол, хүнс	7,415,118.20	9,295,935.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	82,400.00	67,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,329,665.00	4,464,850.00
210604	Урсгал засвар	2,329,665.00	4,464,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,792,400.00	1,820,500.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	230,400.00	325,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,562,000.00	1,495,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,191,377.35	70,529,615.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,593,995.00	9,576,287.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,371,532.00	2,103,477.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	73,225,850.35	58,849,851.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,744,837.99	16,795,742.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,766,939.00	12,494,807.80
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,090,439.00	12,494,807.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,676,500.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,977,898.99	4,300,934.64
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,977,898.99	4,300,934.64
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,134,845,027.69	7,215,590.65
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИИТ ҮР ДҮН	1,134,845,027.69	7,215,590.65

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	623,577,301.00	661,103,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,132,401.00	2,045,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,132,401.00	2,045,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,132,400.00	2,045,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,132,400.00	325,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,720,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	621,444,900.00	659,058,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	453,788,100.00	492,497,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	453,788,100.00	492,497,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	167,656,800.00	166,561,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	167,656,800.00	166,561,000.00
II	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	574,954,826.82	651,937,537.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	574,954,826.82	651,937,537.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	548,488,430.83	632,264,558.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	334,302,096.58	404,964,359.81
210101	Үндсэн цалин	239,634,706.58	284,735,093.04
210102	Нэмэгдэл	67,882,349.00	100,469,546.07
210104	Урамшуулал	10,405,844.00	19,759,720.70
210105	Гэрээт ажлын хөлс	16,379,197.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,185,348.19	51,117,392.97
210201	Тэтгэврийн даатгал	27,378,005.55	34,677,360.43
210202	Тэтгэмжийн даатгал	3,235,945.28	4,743,538.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,339,752.60	3,254,211.95
210204	Ажилгүйдлийн даатгал	848,800.97	766,011.92
210205	Эрүүл мэндийн даатгал	6,382,843.79	7,676,270.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	140,832,884.26	146,260,065.36
210301	Гэрэл, цахилгаан	4,123,147.26	6,885,929.36
210302	Түлш, халаалт	134,402,137.00	134,415,336.00
210303	Цэвэр, бохир ус	2,307,600.00	4,958,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	144,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	144,500.00	-
2105	Нормативт зардал	7,631,829.80	7,945,760.60
210502	Хоол, хүнс	7,631,829.80	7,945,760.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,104,300.00	16,000,000.00

210604	Урсгал засвар	2,104,300.00	16,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,578,200.00	2,219,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	230,400.00	325,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,347,800.00	1,894,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,709,272.00	3,757,480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,353,589.00	916,080.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,355,683.00	2,841,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,466,395.99	19,672,978.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,488,497.00	15,372,044.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,811,997.00	15,372,044.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,676,500.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,977,898.99	4,300,934.64
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,977,898.99	4,300,934.64
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	48,622,474.18	9,166,262.62
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	4,495,000.00	17,014,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,495,000.00	17,014,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,495,000.00	17,014,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,495,000.00	17,014,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(4,495,000.00)	(17,014,900.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	44,127,474.18	(7,848,637.38)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	44,127,474.18
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	44,127,474.18	36,278,836.80

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	262,543,991.52	967,960,981.38	(1,230,466,986.50)	37,986.40
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	262,543,991.52	967,960,981.38	(1,230,466,986.50)	37,986.40
C09	Тайлант үеийн үр дүн	-	-	1,134,845,027.69	1,134,845,027.69
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	262,543,991.52	967,960,981.38	(95,621,958.81)	1,134,883,014.09
D02	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	262,543,991.52	967,960,981.38	(95,621,958.81)	1,134,883,014.09
D03	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D04	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	262,543,991.52	967,960,981.38	(95,621,958.81)	1,134,883,014.09
D10	Тайлант үеийн үр дүн	-	-	7,215,590.65	7,215,590.65
D11	2023 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл	262,543,991.52	967,960,981.38	(88,406,368.16)	1,142,098,604.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	705,331,200.00	664,651,502.74	40,679,697.26	94.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	705,331,200.00	664,651,502.74	40,679,697.26	94.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	685,903,500.00	649,279,458.74	36,624,041.26	94.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	432,707,300.00	404,964,359.81	27,742,940.19	93.6
210101	Үндсэн цалин	295,867,700.00	284,735,093.04	11,132,606.96	96.2
210102	Нэмэгдэл	119,749,900.00	100,469,546.07	19,280,353.93	83.9
210104	Урамшуулал	17,089,700.00	19,759,720.70	(2,670,020.70)	115.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,088,400.00	51,117,392.97	2,971,007.03	94.5
210201	Тэтгэврийн даатгал	36,780,200.00	34,677,360.43	2,102,839.57	94.3
210202	Тэтгэмжийн даатгал	4,327,100.00	4,743,538.39	(416,438.39)	109.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,461,600.00	3,254,211.95	207,388.05	94.0
210204	Ажилгүйдлийн даатгал	865,400.00	766,011.92	99,388.08	88.5
210205	Эрүүл мэндийн даатгал	8,654,100.00	7,676,270.28	977,829.72	88.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	150,561,000.00	146,260,065.36	4,300,934.64	97.1
210301	Гэрэл, цахилгаан	150,561,000.00	146,260,065.36	4,300,934.64	97.1
210302	Түлш, халаалт	150,561,000.00	146,260,065.36	4,300,934.64	97.1
210303	Цэвэр, бохир ус	150,561,000.00	146,260,065.36	4,300,934.64	97.1
2105	Нормативт зардал	9,099,200.00	7,945,760.60	1,153,439.40	87.3
210502	Хоол, хүнс	9,099,200.00	7,945,760.60	1,153,439.40	87.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,219,800.00	2,219,500.00	300.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	325,500.00	325,500.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,894,300.00	1,894,000.00	300.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,227,800.00	20,772,380.00	455,420.00	97.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,386,400.00	17,930,980.00	455,420.00	97.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,841,400.00	2,841,400.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,427,700.00	15,372,044.00	4,055,656.00	79.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,427,700.00	15,372,044.00	4,055,656.00	79.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,227,700.00	15,372,044.00	3,855,656.00	79.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	-	200,000.00	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	705,331,200.00	656,802,865.36	48,528,334.64	93.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	492,497,300.00	492,497,300.00	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	492,497,300.00	492,497,300.00	-	100.0
1311	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	166,561,000.00	162,260,065.36	4,300,934.64	97.1
122005	Орон нутгийн төсвөөс	166,561,000.00	162,260,065.36	4,300,934.64	97.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,145,500.00	2,045,500.00	100,000.00	95.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	325,500.00	325,500.00	-	100.0

350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,820,000.00	1,720,000.00	100,000.00	94.5
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	44,127,400.00	-	4,127,400.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	44,127,474.18		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	36,278,836.80		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 70.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 70.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1 ажилтанд илүү цалин бодож олгосон.	1	70.2	1	70.2								
Дүн	1	70.2	1	70.2								

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 8,400.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 8,400.1 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагыг мэдүүлээгүй.	1	8,400.1			1	8,400.1		
Дүн	1	8,400.1			1	8,400.1		

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.